

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өндөршил сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/108/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэл
Утас: 70592225

Цахим хаяг: oyun-erdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113

Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит
ХХК Утас: 77233030

Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Н.ЦЭРЭНДУЛАМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өндөршил сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Өндөршил сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 51.5 сая төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр данснаас хасаж, ашиглах жилийг шинэчлэн тогтоож, бүртгэлд авч тайлагнасан 75,635.5 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөгүй, шинж чанар агуулгын хувьд материаллаг бус гэж үзээд аудитын дүгнэлтэд нөлөөлүүлээгүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй

4825020234

болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт, 43 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 89.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	117,349,757.87	273,319,437.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	38,471,514.54	187,558,357.79
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	38,471,514.54	187,558,357.79
31210	Төгрөг	38,471,514.54	187,558,357.79
31211	Төрийн сангийн харилцах	36,017,235.29	186,402,078.54
31218	Ахмадын сангийн харилцах	2,454,279.25	1,156,279.25
33	АВЛАГА	5,221,925.00	144,327.26
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,241,925.00	
33103	ХАОАТ-ын авлага	3,241,925.00	
33500	Бусад авлага	1,980,000.00	144,327.26
33510	Байгууллагаас авах авлага	1,980,000.00	144,327.26
35	БАРАА МАТЕРИАЛ	73,656,318.33	85,616,752.33
35100	Түүхий эд материал	26,436,222.74	28,977,986.74
35110	Тусгай зориулалттай материал	26,436,222.74	28,977,986.74
35400	Хангамжийн материал	47,220,095.59	56,638,765.59
35420	Аж ахуйн материал	39,293,625.59	45,735,125.59
35450	Барилгын засварын материал		2,042,500.00
35460	Хүнсний материал	5,532,530.00	6,669,640.00
35470	Бусад хангамжийн материал	2,393,940.00	2,191,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	1,904,347,110.59	2,123,507,809.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,904,347,110.59	2,123,507,809.61
39200	Биет хөрөнгө	1,854,373,748.99	2,074,844,254.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,961,359,795.07	2,217,311,400.07
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(335,216,651.13)	(406,144,538.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,764,027.82	7,764,027.82
39204	Хуримтлагдсан элэгдэл – Тээврийн хэрэгсэл	(7,764,027.82)	(7,764,027.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	236,542,992.14	269,722,126.21
39206	Хуримтлагдсан элэгдэл – Тоног төхөөрөмж	(97,068,266.00)	(89,453,964.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,887,977.00	84,353,343.30
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(21,991,236.32)	(26,513,314.79)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,994,222.00	17,994,222.00
39215	Хуримтлагдсан элэгдэл – Бусад үндсэн хөрөнгө	(6,159,440.83)	(7,161,611.95)
39217	Номын фонд	14,024,357.06	14,736,593.06
39300	Биет бус хөрөнгө	49,973,361.60	48,663,554.88
39301	Програм хангамж	5,079,420.00	5,079,420.00
39302	Хуримтлагдсан элэгдэл – Програм хангамж	(2,787,258.40)	(4,097,065.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	47,681,200.00	47,681,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	2,021,696,868.46	2,396,827,246.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	19,630,315.00	26,786,755.27
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,630,315.00	26,786,755.27
41300	Өглөг	19,630,315.00	26,786,755.27
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		441,300.00
41311	Цалингийн өглөг		441,300.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	16,611,815.00	5,114,800.00
413201	Бичиг хэргийн өглөг	204,000.00	
413203	Түлш халаалтын өглөг	9,509,215.00	
413204	Цэвэр, бохир усны өглөг		77,300.00
413205	Тээвэр, шатахууны өглөг	1,156,600.00	454,900.00
413207	Албан томилолтын өглөг	5,742,000.00	3,928,000.00
413213	Бусад зардлын өглөг		654,600.00
41360	Бусад өглөг	3,018,500.00	21,230,655.27

41361	Байгууллагад төлөх өглөг	3,018,500.00	21,230,655.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	2,002,066,553.46	2,370,040,491.72
51	Засгийн газрын хувь оролцоо	2,002,066,553.46	2,370,040,491.72
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,300,831,913.70	1,300,831,913.70
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	1,300,831,913.70	1,300,831,913.70
51200	Хуримтлагдсан үр дүн	(3,567,408.96)	364,406,529.30
51210	Өмнөх үеийн үр дүн	(3,567,408.96)	(3,567,408.96)
51220	Тайлант үеийн үр дүн		367,973,938.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	704,802,048.72	704,802,048.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	2,021,696,868.46	2,396,827,246.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,006,384,275.61	1,779,429,763.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,212,875.61	358,466,863.44
1200	Нийтлэг татварын бус орлого	87,212,875.61	358,466,863.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,392,088.00	10,043,443.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	11,392,088.00	10,043,443.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	70,776,557.61	345,297,860.44
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	5,044,230.00	3,125,560.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	919,171,400.00	1,420,962,900.00
1310	Улсын төсвөөс	808,664,900.00	1,276,891,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	808,664,900.00	1,276,891,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,506,500.00	144,071,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,506,500.00	144,071,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,054,523,172.27	1,407,580,231.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,054,523,172.27	1,407,580,231.92
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,024,501,325.24	1,378,790,722.43
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	596,091,756.17	902,833,757.00
210101	Үндсэн цалин	433,179,197.00	612,416,832.00
210102	Нэмэгдэл	103,961,276.17	259,132,265.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	29,480,000.00	
210104	Урамшуулал	29,471,283.00	31,284,660.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,073,038.70	109,058,912.75
210201	Тэтгэврийн даатгал	52,150,361.71	75,102,064.32
210202	Тэтгэмжийн даатгал	6,127,825.16	8,900,323.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,883,138.27	4,446,561.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,084,046.37	4,152,290.60
210205	Эрүүл мэндийн даатгал	10,827,667.19	16,457,673.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,296,472.97	132,652,638.25
210301	Гэрэл, цахилгаан	5,305,057.97	10,575,423.25
210302	Түлш, халаалт	108,559,215.00	121,561,115.00
210303	Цэвэр, бохир ус	432,200.00	516,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,674,076.12	11,685,300.00
210401	Бичиг хэрэг	2,360,100.00	1,334,300.00
210402	Тээвэр, шатахуун	4,251,000.00	4,788,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,583,816.12	5,562,300.00
210408	Бараа материал актласны зардал	4,479,160.00	
2105	Нормативт зардал	37,789,980.00	36,541,580.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	653,100.00	
210502	Хоол, хүнс	37,136,880.00	36,541,580.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,907,400.00	2,147,000.00
210604	Урсгал засвар	9,907,400.00	2,147,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,208,000.00	
210702	Дотоод албан томилолт	5,208,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,779,000.00	3,910,731.27
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,779,000.00	3,910,731.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	163,681,601.28	179,960,803.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,604,470.00	11,595,165.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	4,238,785.00	5,863,696.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	148,838,346.28	162,501,942.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,021,847.03	28,789,509.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,921,805.00	28,646,590.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,560,945.00	25,685,590.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,360,860.00	2,961,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	100,042.03	142,919.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	100,042.03	142,919.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	(48,138,896.66)	371,849,531.52
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	3,429,667.58	3,875,593.26
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	3,429,667.58	3,875,593.26
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	645,387.58	3,875,593.26
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал – бараа материал	2,784,280.00	
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(51,568,564.24)	367,973,938.26

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	931,217,488.00	1,432,986,343.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,046,088.00	12,023,443.00
1200	Нийтлэг татварын бус орлого	12,046,088.00	12,023,443.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,046,088.00	12,023,443.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	12,046,088.00	12,023,443.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	919,171,400.00	1,420,962,900.00
1310	Улсын төсвөөс	808,664,900.00	1,276,891,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	808,664,900.00	1,276,891,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,506,500.00	144,071,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,506,500.00	144,071,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	885,134,769.87	1,268,648,631.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	885,134,769.87	1,268,648,631.02
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	855,966,157.84	1,239,857,101.53
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	599,333,681.17	899,150,532.00
210101	Үндсэн цалин	436,597,450.53	621,667,491.00
210102	Нэмэгдэл	103,784,947.64	245,902,921.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	29,480,000.00	
210104	Урамшуулал	29,471,283.00	31,580,120.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,073,038.70	109,058,912.75
210201	Тэтгэврийн даатгал	52,090,542.20	75,102,064.32
210202	Тэтгэмжийн даатгал	6,009,911.40	8,900,323.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,819,662.91	4,446,561.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,104,831.55	4,152,290.60
210205	Эрүүл мэндийн даатгал	11,048,090.64	16,457,673.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,793,857.97	142,228,880.51

210301	Гэрэл, цахилгаан	5,305,057.97	10,719,750.51
210302	Түлш, халаалт	99,050,000.00	131,070,330.00
210303	Цэвэр, бохир ус	1,438,800.00	438,800.00
2105	Нормативт зардал	40,067,110.00	37,371,690.00
210502	Хоол, хүнс	40,067,110.00	37,371,690.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,712,600.00	5,200,000.00
210604	Урсгал засвар	6,712,600.00	5,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,354,500.00	6,335,231.27
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,354,500.00	6,335,231.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,631,370.00	40,511,855.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,600,320.00	35,042,455.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	5,031,050.00	5,469,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,168,612.03	28,791,529.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,068,570.00	28,648,610.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,707,710.00	25,687,610.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,360,860.00	2,961,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	100,042.03	142,919.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	100,042.03	142,919.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	46,082,718.13	164,337,711.98
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	15,585,000.00	15,250,868.73
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,585,000.00	15,250,868.73
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	15,585,000.00	15,250,868.73
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	15,585,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,585,000.00	15,250,868.73
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(15,585,000.00)	(15,250,868.73)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	30,497,718.13	149,086,843.25
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,973,796.41	38,471,514.54
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,471,514.54	187,558,357.79

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,300,831,913.70	704,802,048.72	48,001,155.28	2,053,635,117.70
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,300,831,913.70	704,802,048.72	48,001,155.28	2,053,635,117.70
9	Тайлант үеийн үр дүн			(51,568,564.24)	(51,568,564.24)
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,300,831,913.70	704,802,048.72	(3,567,408.96)	2,002,066,553.46
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,300,831,913.70	704,802,048.72	(3,567,408.96)	2,002,066,553.46
19	Тайлант үеийн үр дүн			367,973,938.26	367,973,938.26
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,300,831,913.70	704,802,048.72	364,406,529.30	2,370,040,491.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,468,831,600.00	1,282,458,580.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,468,831,600.00	1,282,458,580.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,440,129,600.00	1,253,809,970.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,025,528,500.00	899,150,532.00
210101	Үндсэн цалин	706,862,900.00	621,667,491.00
210102	Нэмэгдэл	301,071,500.00	245,902,921.00
210104	Урамшуулал	17,594,100.00	31,580,120.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,191,100.00	109,058,912.75
210201	Тэтгэврийн даатгал	87,170,000.00	75,102,064.32
210202	Тэтгэмжийн даатгал	10,255,300.00	8,900,323.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,127,600.00	4,446,561.60
210204	Ажилгүйдлийн даатгал	5,127,600.00	4,152,290.60
210205	Эрүүл мэндийн даатгал	20,510,600.00	16,457,673.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	142,371,800.00	142,228,880.51
210301	Гэрэл, цахилгаан	10,859,800.00	10,719,750.51
210302	Түлш, халаалт	131,070,400.00	131,070,330.00
210303	Цэвэр, бохирус	441,600.00	438,800.00
2105	Нормативт зардал	71,223,200.00	37,371,690.00
210502	Хоол, хүнс	71,223,200.00	37,371,690.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,200,000.00	5,200,000.00
210604	Урсгал засвар	5,200,000.00	5,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,354,600.00	13,354,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг үйлчилгээ		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,354,600.00	13,354,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,260,400.00	47,445,355.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,791,000.00	41,975,955.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,469,400.00	5,469,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,702,000.00	28,648,610.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,702,000.00	28,648,610.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,739,500.00	25,687,610.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,962,500.00	2,961,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,468,831,600.00	1,432,843,423.51
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,276,891,100.00	1,276,891,100.00
122005	Улсын төсвөөс санхүүжих	1,276,891,100.00	1,276,891,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	144,071,800.00	143,928,880.51
132001	Орон нутгийн төсвөөс	144,071,800.00	143,928,880.51
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	47,868,700.00	12,023,443.00
120010	Төсөвт байгууллагын өөрийн орлого/туслах/	11,853,300.00	12,023,443.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	36,015,400.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		36,017,235.29
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		186,402,078.54

Гурав. Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн буруу илэрхийллийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 78,407.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 258.5 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, зөрчлийг арилгуулахаар 2,513.0 мянган төгрөгийн хугацаатай 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 75,635.5 мянган төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлжээ.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 258.5 мянган төгрөгийн 2 алдаа¹ илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- 238.6 мянган төгрөгийн өр төлбөрийг хасах тэмдэгтэй тайлагнасан.
- Цэвэр бохир усны зардлыг анхан шатны баримтаас 19.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4./үнэн зөв байх;/ дах заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 78,148.5 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрч, 2,513.0 мянган төгрөгийн зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага, зөрчлийг дахин гаргуулахгүй байх 75,635.5 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлжээ.

3.1 Албан шаардлага

Нягтлан бодогч, нярвын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 2,513.0 мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т заасныг зөрчсөн.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой.

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглах боломжтой 75,635.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр данснаас хасаж, ашиглах жилийг шинэчлэн тогтоож, бүртгэлд авч тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т /Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д /өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах/, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, данснаас хасах шилжүүлэх” журмын 1.5-д /Сумын харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээд мотоцикл болон бусад хөдлөх хөрөнгийг олж авах, акталж данснаас хасах, худалдах, шилжүүлэх саналаа энэ журмын дагуу баримт бүрдүүлэн сумын ИТХ-д уламжилж шийдвэрлүүлнэ./, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 он 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, данснаас хасах шилжүүлэх” журмын 7.2 -т /Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа дахин ашиглах

¹Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана./ тус тус заасныг зөрчсөн мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа дахин ашиглах боломжтой хөрөнгийг данснаас хасах асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлэх, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж, хэрэгжилтийг 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг Дундговь аймгийн Өндөршил сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Цэрэндулам, нягтлан бодогч Х.Үнэнтунгалаг нарт зөвлөж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөрийг хасах тэмдэгтэй тайлагнасан.	1	238.6			1	238.6	1	238.6		
Цэвэр бохир усны зардлыг анхан шатны баримтаас дутуу тайлагнасан	1	19.9			1	19.9	1	19.9		
Дүн	2	258.5	0	0	2	258.5	2	258.5	0	0

2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогч нярав нарын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон.	1	2,513.0			1	2,513.0				
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр данснаас хасаж, ашиглах жилийг шинэчлэн тогтоож, бүртгэлд авч тайлагнасан.	1	75,635.5					1	75,635.5		
Дүн	2	78,148.5			1	2,513.0	1	75,635.5	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таагалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1	1		